

**ИРГЭД ХАРИЛЦАН ЗОРЧИХ ЖУРМЫН ТУХАЙ БҮГД
НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар тус хоёр улсын найрамдалт харилцааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэх эрмэлзлийг удирдлага болгон иргэд харилцан зорчих журмын талаар дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын үндэсний хүчин төгөлдөр дипломат, албан, албаны зориулалт бүхий энгийн паспорттай иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр зорчиж буку дамжин өнгөрч болно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын хил орчмын худалдааны ажил эрхэлдэг ажилтнууд болон хил орчмын худалдааны зориулалттай тээврийн хэрэгслийн жолооч нар энэ Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан паспорт буку өөрийн улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үнэмлэхээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хил орчмын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр зорчиж болно.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн үндэсний хүчин төгөлдөр паспорт болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын визтэй бол түүний нутаг дэвсгэрт хувийн хэргээр байнга оршин суухаар орж болно.

Дөрөвдүгээр зүйл

Энэ Хэлэлцээрийн нэг, хоёрдугаар зүйлд заасан визгүйгээр зорчих иргэдээс бусад Хэлэлцэн тохирогч нэг Талын үндэсний хүчин төгөлдөр паспорттай иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түүний визтэйгээр хувийн хэргээр зорчиж буку дамжин өнгөрч болно.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын 18 нас хүрээгүй хүүхэд үндэсний хүчин төгөлдөр паспортаараа, эсвэл түүнтэй хамт явах эцэг, эх буку

иргэний адил харьяалалтай хүний хүчин төгөлдөр паспортад хавсаргасан баримт бичгээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ Хэлэлцээрт заасны дагуу зорчиж буку дамжин өнгөрч болно.

Зургаадугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчих буку дамжин өнгөрөхдөө Хэлэлцэн тохирогч хоёр Талын улсын хилийн олон улсын зорчигчдод нээлттэй боомтоор нэвтрэнэ.

2. Энэ Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд заасан иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчихдоо Хэлэлцэн тохирогч хоёр Талын тохиролцсон боомтоор нэвтрэнэ.

Долоодугаар зүйл

1. Энэ Хэлэлцээрт заасны дагуу зорчих Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа Хэлэлцэн тохирогч тэр Талын хууль дүрмийг хүндэтгэн сахих үүрэгтэй.

2. Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг тааламжгүй этгээд буку хүлэж авах боломжгүй гэж үзвэл түүнийг нутаг дэвсгэртээ оруулахаас татгалзах, нутаг дэвсгэртээ байлгах хугацааг богиносгох эрхтэй бөгөөд ингэсэн шалтгаанаа тайлбарлах үүрэггүй.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдэд энэ Хэлэлцээрийн гурав, дөрөвдүгээр зүйлд заасны дагуу виз олгох, сунгах, өөрчлөх, хавсаргах, байнга оршин суух зөвшөөрөл олгох, ийм зөвшөөрлийн хугацааг сунгахдаа хууль дүрмийнхээ дагуу хураамж авна.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал иргэд харилцан зорчиход хүчин төгөлдөр үндэсний паспорт, зөвшөөрлийн үнэмлэхийн загваруудыг энэ Хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш 20 хоногийн дотор солилцоно. Хэлэлцэн тохирогч нэг Тал шинэ паспорт, зөвшөөрлийн үнэмлэх хэрэглэх болвол энэ тухайгаа 60 хоногийн өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа мэдэгдэж загварыг өгч байна.

Аравдугаар зүйл

1. Энэ Хэлэлцээр гарын үсэг зурсан өдрөөс хойш 30 дахь хоногоос хүчин төгөлдөр болно. Энэ Хэлэлцээрийг тодорхой хугацаагүйгээр байгуулав.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь энэ Хэлэлцээрийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдсэнээс хойш 90 дэх хоногоос энэ Хэлэлцээр хүчингүй болно.

3. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь улсын ажуулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах бухуу гоц халдварт өвчин болон байгалийн гай гамшиг зэрэг онцгой тохиолдолд энэ Хэлэлцээрийг бүхэлд нь бухуу түүний зарим заалтыг хэрэгжүүлэхээ түр зогсоож болох бөгөөд энэ тухайгаа уг арга хэмжээ авахаас 72 цагийн өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

Арван нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал тохиролцож энэ Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Энэ Хэлэлцээрийг 1989 оны *сүрэлдүгээр* сарын 30 -нд Бээжин хотод хятад, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд хоёр эх хувь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

钱其琛

(ЦЯНЬ ЦИЧЭНЬ)

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ
АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС



(Ц.ГОМБОСҮРЭН)